

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234724

МОНГОЛ, ТУВА ХЭДЭН БӨӨГНӨЛ ҮЛГЭРИЙН ТУХАЙ

М.Ууганбаяр

Түлхүүр үг. монгол түрэг үлгэр , тува үлгэр, бөөгнөл үлгэр, бөөгнөх арга

Дэлхийн аман зохиолд үлгэрийн өгүүлэмж мөчлөгөөр давтах бөөгнөл /кумуляция/ гэх арга буй. Бөөгнөл үлгэрт кумулятивная сказка шинэ дүр, дүрүүдийн тоо нэмэгдэх зэргээр үйл явдал олон дахиж давтагддаг. Бөөгнөл үлгэр бол үлгэрийн нэг зүйл бөгөөд германчууд /Zahlmarchen/ эргэц үлгэр гэж нэрлэх ажээ. Басангова Манджиева 177

В. Я. Пропп бөөгнөл үлгэрийн хүүрнэх бүтэц зохион байгуулагдах үндсэн зарчмыг гинжин хэлхээ алдрах тасалдах хүртэл эсвэл сүлжих дэс дараа өөрчлөгдөх хүртэл нэг адил үйл явдлууд буюу махбодууд олон дахин давтагдах шинжээр тодруулжээ. (Пропп 1976 : 243) Бид урьдах өгүүлэмж адил хэд хэдэн бөөгнөл бүтэцтэй үлгэрийг ялган харуулав.

Аман зохиол судлаач гадаадын эрдэмтэд монгол халимг буриад тува бөөгнөл үлгэрийг судалжээ. Д. А. Носов монгол буриад бөөгнөл үлгэрийг, Т. Г. Басангова, Д. В. Убушиева, Б. Б. Манджиева нар халимаг бөөгнөл үлгэрийг, Б.-Х. Б. Цыбикова буриад бөөгнөл үлгэрийг судалжээ. (Носов 2010: 87, Носов 2011: 19-21, Басангова, 2002: 193-195, Басангова 2018: 51-52, Басангова, Манджиева 2011: 177–188, Манджиева 2011: 100-106, Убушиева 2017: 139- 151, Цыбикова 2020: 433) З. Б. Самдан тува үлгэрийн эмхтгэлдээ хэд хэдэн тува бөөгнөл үлгэрийг ялган тодруулжээ.(Самдан 1994: 380-392)

Бидний харьцуулан авч үзэж буй “Мөнгөн ташаатай хулгана” гэх монгол үлгэр “Күскениң шинчилели” (Хулганын бодол) гэх тува үлгэр адил өгүүлэмжтэй бөөгнөл хувилбар үлгэрүүд юм.

Мөнгөн ташаатай хулгана

Мөнгөн ташаатай хулгана эрт цагт
Мөсөн дээр хальтирч унаад
Мөнгөн ташаагаа гэмтээчихэв гэнэ
Мөснөөс ийнхүү асуув гэнэ
Мөс чи миний
Мөнгөн ташааг хугалав

Мөс чи тэгэхлээр
Хамгийн хэцүү нь
Мөнгөн ташаатай хулгана минь
Мөсхөн би хэцүү бишээ
Надаас нар хэцүү билээ
Нар намайг хайлуулчихдаг билээ
Мөнгөн ташаат хулгана
Мөнөөхөн нартай уулзаад
Нар чи хамгийн хэцүү нь мөн үү?
Надад үүнийгээ айлтгахсан болов уу?
Найзгүй мөс мөнгөн ташааг минь хугалчихаад
Намайг чам уруу илгээсэн юм
Нар надаас илүү хэцүү
Намайг бүхэлд нь халхалчихдаг юм
Үүлнээс та асуул даа
Үнэхээрийн тэр хэцүү шүү
Мөнгөн ташаатай хулгана
Мөнөөхөн үүлтэй уулзаад
Үүл чи үнэхээр хэцүү том уу?
Үзэсгэлэнт нарыг халхалчихдаг чинь үнэн үү?
Үүнийг л би мэдэх гэсэн юм аа
Үнэндээ би мунгинаж л явна
Салхи л хамгийн хэцүү дээ
Сарниулаад намайг хөөчихдөг юм
Салхинаас үүл хүчтэнг
Санаад санаад би мэдэхгүй
Мөнгөн ташаатай хулгана
Мөнөөхөн салхитай уулзаад
Салхи чамайг үүлнээс хэцүү гэж
Саяхан би түүнээс сонслоо
Салхи чи тэгэхлээр ертөнцөд
Санашгүй хэцүү нь мөн үү?
Уу аа худалч тархи гэж
Уул надаас хавьгүй хэцүү
Унаган биеийг минь тэр чигээр нь
Уул гуай л эвдэлдэг юм шүү дээ!
Мөнгөн ташаатай хулгана
Мөнөөхөн уултай уулзаад
Уул чамайг айхтар хэцүү гэж
Улс амьтнаас сонсоод ирлээ
Энэ хэрвээ үнэн болбоос
Эрлээ би эцэслэх гэсэн гэсиймаа!
Хаанаас даа эрхэм хулгана гуай
Хонь мал надаас их хэцүү
Хойно урдаас авирч намайг гишгэлдгийм

Хоосортол минь идэслэж нүцгэлдгийм!
 Мөнгөн ташаатай хулгана
 Мөнөөхөн хонь малтай уулзаад
 Хонь мал та нарыг чинь
 Хосгүй хэцүү нь мөн гэж
 Холоос яваа би сонслоо
 Хойтохоо даатгая гэж ирлээ
 Хош цөг! Хулгана та юу айлдана?
 Хонь мал бид ноомой амьтад
 Молхи маниараа зоог барьдаг
 Модон сүүлт /чоно/л хамгийн хэцүү!
 Мөнгөн ташаатай хулгана
 Мөнөөхөн модон сүүлттэй уулзаад
 Модон сүүлт чамайг хамгийн хэцүү нь гэж
 Мөнх тэнгэрийн доор хамгийн чадалтай нь гэж
 Мөнгөн ташаат би сонсоод биширлээ
 Мөн үү, бишүү хэлээд өгөөч?
 Моньд минь хэн чамд тэгж хэлээв?
 Модон сүүлт би андуу сонсов уу?
 Хоёр хөлт хохимой гэгч
 Хорвоод хамгийн хэцүү нь шүү дээ!
 Мөнгөн ташаатай хулгана
 Мөнөөхөн хоёр хөлт хохимойтой уулзаад
 Хоёрт хөлт хохимой чамайг
 Хорвоод хамгийн хэцүү нь гэж сонслоо
 Мөнгөн ташаат хулгана надтай
 Мөчөөрхсийм биш биз арай чи!?
 Ихэмсэг хулганын хэрсүү үгэнд
 Инээд нь хүрсэн хоёр хөлт хохимой
 Ингээд томорч бай! гэж хэлээд
 Ивэртэл нь няслаад хийсгэчихэв гэнэ. (Катуу 2004: 398)

Күскениң шинчилели

Бир-ле эртен күске дош кырлап кежип чыткаш, дайгактааш, барып ушкан.

-Бо дош деп чүвениң күштүүн аа!-дээш, көрүп олуарга, хүннүн чылыынга эстип турар болган.

-Уваа, хүн кончуг мөге чүве турган чүл-дээш, көрүп олуарга, булутка дугладыптар болган.

-Ындыг эвес, булут күштүг чүве турган чүл-дээш, бедик даг бажындан көрүп олуарга, булут дээрге, хат кайнаар-ла кагадыр, ооң кара аайы-биле ынаар көжүп чоруп турар болган.

-Чок, хат күштүг болбааже аан, моң-дээш, хат хадыырын манап көрүп олуарга, бичии чүвелерни коргудуп, силгип, үрей шаап турза-даа хая-дашты, тайга-сынны угбас болган.

-Чүү-даа канчаар, хая-даш, тайга-сын кончуг күштүг чүве эвеспе, моозу-дээш, күжүр күске шинчилел көрүп олуарга өрге, тарбаган үнгүр кылып ойнап турар- мындыг болган.

-Карак, сүлде-ле бо! Өрге, тарбаган ушчок күштүг амытан-дыр ийин, моң — дээш, көрүп олуарга, кижиден коргар, өлүртүп кааптар болуп-тур.

-Эжен сүлде, эдер-деңгер-ле бо! Бо кижиде деп амытаныңар кончуг шүүлген чүве эвес ыйнаан-дээш, хөй-ле кижилиг черлер дилеп чоруп каап-тыр.

Ол-ла ынчап чорааш, бир-ле улуг хүрээ чөргө чедип келген. Кижилерни көрүп турарга, бурганга чүдүп-тейлеп турар — мындыг болган.

-Хувурай бер, бурган кончуг күштүг амытан эвес ыйнаан — дээш, бурганга чеде бергеш:

-Бо-ла өлүг, дириг амытаннарда сенден күштүг чүве чок чүве-дир аа, бурган? — деп айтырган. Бурган ыыттаваан.

-Бо кандаай чоор, дүлей чүве бе? — дээш, оон-даа дыңналдыр айтырган. Ыыттаваан.

Ам мырыңай бар-ла турган күжү-биле алгырып айтырган База ыыттаваан.

-Элдептиин аа! Азы кижиден өске чүве-биле чугаалашпас чүве бе?-дээш, долгандыр маңнагылааш, көрүп турарга, анаа-ла бир хола, чес, малгаш, саазын чүү-хөө чүвөлөрдөн холуксаалап туруп кылган, хей хоозун чүве болган.

-Ээче, хувурай бер, ай-ана, кижилерниң чүдүп чоруур бурган деп чүвези-даа хей чүве-дир, мооңар. Шаа кээрге биле-ле бээрлер ыйнаан, че, мен хөөкүйдө чүү боор, маңаа чурттай-ла бербес мен бе- дээш, улустуң бурганга салган эът-чемин, үс-саржаан ижип. чип, ооң хос холургай бажының иштинге уя туткаш, чурттай берип-тир оо! (ТТ II 1955:200-202)

Хулганын бодол

Нэг өглөө хулгана мөсөн дээгүүр явж байгаад хальтарч унажээ. “Энэ мөс гэгч хүчтэй юм аа !” гэж хартал нарны илчинд хайлсан байжээ.

-Нар маш хүчтэй юм байна гээд харж байтал үүлэнд халхлагдсан байжээ.

-Ийм биш, үүл хүчтэй юм байна гээд өндөр уулын оройгоос хартал, салхи хаашаа хөдлөнө, үүл аясаар нь дагаж нүүж байв гэнэ.

-Үгүй салхи хүчтэй юм гээч гээд салхи салхилахыг хүлээж байтал, салхи өчүүхэн жижиг амьтсыг л айлган сэгсчиж, эвдлэн сүйтгэлээ ч хад чулуу, тайга бэл газрыг яах ч үгүй байв гэнэ.

-Юу ч болов, хад чулуу тайга бэл л маш хүчтэй юм биш үү гээд хөөрхий хулгана бодож байтал хад чулуунд үүрээ ухсан оготно тарвага хошгирон наадаж байна гэнэ.

-Нүд сүлд минь! Оготно тарвага чинь дийлдэшгүй хүчтэй амьтан юм гээч гээд хартал хүнээс айж үхсэн байв гэнэ.

-Эзэн сүлд дуут тэнгэр минь ! Энэ хүн гэж амьтан хамгийн манлай нь юм гээч гээ; олон хүнтэй газар хайж явж гэнэ.

Тэгж яваад том хүрээ газар иржээ. Хүмүүсийг хартал, бурханд сүсэглэж, залбирч байх аж.

-Халаг гэж. бурхан маш хүчтэй амьтан юм гээч гээд бурханд хүрч очоод:

-Энэ үхсэн амьд амьтас дунд чамаас илүү хүчтэй амьтан алга тийм үү бурхан? гэж асуужээ. Бурхан дуугарсангүй гэнэ.

-Энэ дүлий юм уу гээд түүнд сонстохоор асуужээ. Дуугарсангүй гэнэ.

Тэгээд хамаг чадлаараа бархиран асуув. Бас л дуугарсангүй гэнэ.

-Хачин жигтэй юм! Эсвэл хүнээс өөр амьтантай ярьдаггүй юм болов уу гээд ийш тийш гүйж харайгаад хартал, бурхан гэгч нь зэс, шавар, цаас, юм хум холилдсон хий хоосон юм байв гэнэ.

-Халаг гэж, хүмүүсийн шүтээд байдаг бурхан ч хоосон зүйл аж. Цаг нь ирэхэд туслахгүй биз, хөөрхий би яахав энд амьдрахгүй гээд хүмүүсийн бурханд тавьсан мах идээ шар тосноос ууж идэн, гуулин бурхны хоосон толгой дотор үүрээ барьж амьдрал гэнээ !

Бидний харьцуулан авч үзэж буй “Болдоггүй Боролзой өвгөн” “Болдоггүй бор өвгөн” гэх монгол үлгэрүүд, “Муң хойлуг Бумбаадай” (Мянган хоньтой Бумбаадай) гэх тува үлгэр адил өгүүлэмжтэй бөөгнөл хувилбар үлгэрүүд юм.

Болдоггүй Боролзой өвгөн

Эрт урьд цагт болдоггүй Боролзой өвгөн гэж нэг өвгөн байж гэнэ. Энэ өвгөн долоон бор хоньтой, нисдэг бор морьтой, бас нисдэггүй бор морьтой юм гэнэ. Болдоггүй Боролзой өвгөн Болзоотын бор толгойн тэнд овоохой бариад суудаг байжээ. Болзоотын бор толгойд долоон бор хонио хариулдаг байжээ. Нисдэг бор морио гэрийнхээ баруун талд уядаг, нисдэггүй бор морио зүүн талдаа аргамждаг байжээ.

Болдоггүй Боролзой өвгөн “Хув бор хониноос минь хундан цагаан хурга гараасай, Хурмаст тэнгэрээ тайх юм сан” гэж бодож явдаг байжээ. Тэгж байтал хув бор хониноос нь хундан цагаан хурга гарсанд, Хурмаст тэнгэрээ тахина гэж баярлаад хурганы уутанд хийж хээр тавиад, хонио буцаагаад ирсэн чинь Хурмастын хон хэрээ нисэж ирээд хурганых нь нүдийг ухчихсан байж гэнэ. Болдоггүй Боролзой өвгөн уурлаж, нисдэг бор морио унаж, нисэж очоод хон хэрээний эвэр хошууг нь аваад, модон хошуу хийгээд тавьчхаж гэнэ.

Гэтэл Хурмаст тэнгэр “Хон хэрээний минь хошууг солилоо” гэж уурлаад хоёр чоноороо нисдэг бор морийг идүүлэхээр явуулж гэнэ. Үүнийг болдоггүй Боролзой өвгөн мэдээд нисдэг бор морио зүүн талдаа, нисдэггүй бор морио баруун талдаа солиод аргамжиж гэнэ. Хурмаст хааны хоёр чоно ирээд нисдэггүй бор морийг нь идчихээд явчхаж гэнэ. Болдоггүй Боролзой өвгөн нисдэг бор морио унаж хөөж очоод хоёр чонын арьсыг өвчөөд хоншоорт нь унжуулаад тавьчхаж гэнэ.

Тэгэхлээр Хан Хурмастаас болдоггүй Боролзой өвгөнийг даруулахаар Мичид толгойт, Марал толгойт хоёр чөтгөрөө явуулж гэнэ. Болдоггүй Боролзой өвгөн хоёр чөтгөрийг ирэхэд тогоо дүүрэн адууны сэвс буцалгаж байжээ. Хоёр чөтгөр ирээд ханын нүдээр шагайхад нь халуун сэвс цацаад нүүр амыг нь шалзлаад явуулж гэнэ. Хан Хурмаст уурлаж, болдоггүй Боролзой өвгөнийг хоёр луугаараа ниргүүлэхээр явуулжээ. Болдоггүй Боролзой өвгөн үүнийг мэдэж Болзоотын бор толгойд хонио хариулж явснаа бор хурган дахаар (боролж шарилжаар) мануухай босгочхоод гэнэт холдоод өөр газар яваад өгчээ. Хоёр луу Болзоотын бор толгойг

бор нүүрс болтол нь ниргээд явчихжээ. Болдоггүй Боролзой өвгөн нисдэг бор морио унаж нисэж хөөж очоод хоёр лууны сүүлийг тас цавчаад явуулчихжээ.

Хан Хурмаст уурлаж “Болдоггүй Боролзой өвгөнийг цаазаар авна” гэж элчээр дуудуулсанд өвгөн, Хурмаст хааныд очжээ. Хан хурмаст:

-Чи яагаад хэрээний минь эвэр хошууг модон хошуугаар сольсон? гэж асууж гэнэ.

-Хув бор хониноос минь хундан цагаан хурга гарвал Хурмаст тэнгэрээ тахих юм сан гэж бодож явтал хув бор хониноос минь хундан цагаан хурга гарахаар нь Хурмаст тэнгэрээ тайна гэж баярлаж байтал хон хэрээ нисэж ирээд хоёр нүдийг нь ухчихаад явчихлаа. Тэгэхлээр нь би уурлаж хэрээний хошууг сольсон гэж хэлжээ.

-Тэгвэл тэр чиний зөв. Харин яах гэж хоёр чонын минь арьсыг хоншоорт нь унжуулж тавив? гэж Хурмаст асууж гэнэ.

-Та нисдэг бор морийг минь идээд ир гэсэн үү? Нисдэггүй бор морийг минь идээд ир гэсэн үү? гэж Хурмастаас өвгөн асууж гэнэ.

-Нисдэг бор морийг нь ид гэж явуулсан юм!

-Тэгвэл тэр хоёр чоно чинь нисдэггүй бор морийг минь идчихээр нь би уурлаад арьсыг нь хоншоорт нь чиргүүлээд тавьсан гэж гэнэ.

-Тэгвэл тэр чиний зөв. Харин яагаад хоёр чөтгөрийн минь нүүрийг шалз булз түлэв? гэхлээр нь өвгөн:

-Та болдоггүй Боролзой өвгөнийг хорлоод ир гэсэн үү? Бор овоохойг минь цоолоод ир гэсэн үү? гэж асуув.

-Болдоггүй Боролзой өвгөнийг хорлоод ир гэсэн! гэв.

-Болдоггүй Боролзой өвгөнийг хорлохын оронд бор овоохойг минь цоолоод ураад байхаар нь би нүүрийг нь түлсэн гэжээ.

-Харин өвгөн чи миний хоёр лууны сүүлийг яагаад тас цавчсан билээ? гэж Хан Хурмаст асуув.

-Болдоггүй Боролзой өвгөнийг нь хорлоод ир гэсэн үү? Болзоотын бор толгойг ниргээд ир гэсэн үү? гэж өвгөн асуув.

-Болдоггүй Боролзой өвгөнийг ниргээд ир гэсэн! гэж.

-Тэгвэл болдоггүй Боролзой өвгөнийг ниргэхийн оронд Болзоотын бор толгойг бор нүүрс болтол ниргэхээр нь би хоёр лууны сүүлийг тас цавчсан гэв. Хурмаст хаан:

-Тэгвэл тэр чиний зөв гэжээ.

Ингээд Болдоггүй Боролзой өвгөн долоон бор хоньтойгоо, нисдэг бор морьтойгоо амар сайхан жаргажээ. (Цэрэнсодном 1982: 82-83)

Болдоггүй бор өвгөн

Эрт урьд цагт Болдоггүй бор өвгөн гэж түмэн бор хоньтой нэгэн өвгөн байжээ. Болдоггүй бор өвгөн нисдэг бор морь, нисдэггүй бор гэж хоёр бор морьтой, бас нэгэн шувуутай юмсанжээ. Болдоггүй бор өвгөн бүх насаараа “Хар хурга гараасай хааныхаас дутахгүй юмсан. Бор хурга гараасай богдынхоос дутахгүй юмсан” гэж хүсдэг байжээ. Гэтэл нэгэн өдөр хар хурга гарсан чинь Хурмаст хааны хоёр хар хэрээ ирээд нүдийг нь ухаад явчихжээ. Тэгэхээр нь болдоггүй

бор өвгөн нисдэг бор мориороо хүрч очоод хоёр хар хэрээний нүдийг нь ухаад явчихаж гэнэ. Буцаж ирээд шувуундаа,

– За чи хааныд очоод юу гэж ярилцаж байгааг мэдээд ир хэмээв.

Шувуу нь нисч очоод хааны гэрийн тоонон дээр сууж байтал болдоггүй бор өвгөний нисдэг бор морийг нь хоёр чоноор идүүлье гэж байна гэнэ.

Түүнийг шувуу сонсоод өвгөндөө ирж хэлэв. Өвгөн нисдэг бор морио үүдэндээ уяж нисдэггүй бор морио гэрийнхээ хойно уяж гэнэ. Гэтэл Хурмаст хааны хоёр чоно ирээд нисдэггүй бор морийг нь идээд явжээ. Чингэхээр нь нисдэг бор мориороо хоёр чоныг хөөж гүйцээд хоншоорыг нь тас цавчаад алчихаж гэнэ. Өвгөн гэртээ ирээд нөгөө шувуугаа бас хааных руу явуулжээ. Шувуу урьдын адил тоонон дээр нь суугаад чагнаж байтал хаан ихэд хилэгнэж,

-Болдоггүй бор өвгөнийг чөтгөрөөрөө хорлуулмуй! гэж байв. Шувуу үүнийг сонсоод өвгөнд очиж хэлэв. Өвгөн нисдэггүй бор мориныхоо сэвсийг буцалгаж эхэлжээ. Гэтэл хоёр чөтгөр ирээд овоохойг нь цоолоод харж байна гэнэ. Чингэхээр нь Болдоггүй бор өвгөн хоёр чөтгөрийн урдаас халуун сэвсийг цацжээ. Хоёр чөтгөр түлэгдээд үхэж гэнэ. Дараа нь бас л Хурмастын хааны уруу шувуугаа явуулсанд Болдоггүй бор өвгөнийг хоёр луугаараа ниргүүлнэ гэж хаан ярьж байна гэж шувуу нь буцаж ирээд хэлжээ. Үүнийг сонсоод өвгөн болзоотын бор толгой дээр хонио орхиод гэртээ ирж гэнэ.

Гэтэл өнөө хоёр луу нь Болзоотын бор толгойг хар нүүрс болтол ниргээд буцаж гэнэ. Өнөө өвгөн нисдэг бор мориороо хоёр лууг нь хөөж гүйцээд хоёр хөлийг нь тас цохилд явуулжээ. Луу буцаж очоод бидний хөлийг тас цохилоо, бид хөлгүй хэрхэн амьдрах билээ гэжээ. Хурмаст хаан: - “Одоо би ямар юмаа явуулах билээ” гэж бодож байгаад өөрөө Болдоггүй бор өвгөнийд ирээд:

-Чи миний хоёр хэрээний нүдийг яагаад сохлов? хэмээн асуухад өвгөн:

-Би бүх насаараа хар хурга гараасай, хааныхаас дутахгүй юмсан. Бор хурга гараасай, богдынхоос дутахгүй юмсан гэж хүсдэг байлаа. Гэтэл нэгэн хар хурга гарсан чинь хоёр хэрээ ирээд нүдийг нь сохолчихов. Чингэхээр нь нүдийг нь адилхан сохлов гэж өвгөн өчжээ. Хурмаст хаан:

-Таны зөв байхаа. Харин яагаад хоёр чонын хоншоорыг тас цавчив? гэхэд өвгөн:

-Та нисдэг бор морийг нь идээд ир хэмээснээс биш нисдэггүй морийг минь идээд ир гэж хэлээгүй биз дээ хэмээсэнд Хурмаст хаан,

-Чингэвээс чонын хоншоорыг тас цавчсан чинь болжээ. Харин чи яагаад хоёр чөтгөрийг минь алав? гэхэд өвгөн:

-Та хоёр чөтгөрийг явуулахдаа хар гэрийг нь цоол хэмээсэн үү, халуун амийг нь тасал хэмээсэн үү? гэхэд,

-Чөтгөрийг алсан нь зөв байна. Тэгвээс яагаад хоёр лууны хөлийг хуга цохив гэж хаан асуув.

-Та болзоотын бор толгойг ниргээд ир хэмээсэн үү? Болдоггүй бор өвгөнийг ниргэ хэмээсэн үү? хэмээхийг хаан сонсоод,

-Луугийн хөлийг хугалсан нь зөв байна хэмээгээд өвгөнөөс айгаад гэрт нь оролгүй яваад өгчээ.

Чингээд Болдоггүй бор өвгөн ам хэл, сэцэн ухаанаар Хурмастын хааныг айлгаж амар сайхандаа жаргажээ. (ХЗХ :2)

Муң кара хойлуг Бумбаадай

Шыяан, биеэде эртенгиниң эртезинде, бурунгунуң мурнунда буга-деге мыйызы буступ дүжүп, калбак чүве халып, борбак чүве чугдуп турар шагда чүвөң иргин эвеспе аан. Кашпалданып баткан кара хемниң унун чурттаан муң кара хойлуг, Эки-Бора, Багай-Бора ийи аъттыг Бумбаадай ирей чоруп-тур. Бумбаадай ирей бир эртен хоюн ончалап чоруурга, бир хою ийи ак хураган төрүп алган чыткан. Ашак оон өөрээш, ыштыг кара чадырынга халып келгеш, ийи инчөөк дааран алгаш, дедир халывышаан чеде бээрге, ийи ак хураганының карактарын ийи кара кускун деже соктап чип алган олуруп-турлар. Ашак-даа хорадавас боду хорадап, ажынмас боду ажынып келгеш, Эки-Боразын мунгаш, ийи кара кускунну Болчаглыг-Бора-Тейни үш долгандыр сывыргаш, барып четкеш, туткулап алгаш, ол кускуннарның карактарын дешкеш, диригге салгылап-тыр.

Ам чүзү боор, демги ийи кара кускун ол-бо ужуп чоруткаш, үстүү оранда кудайның хаанынга баргаш:

-Муң кара хойлуг Бумбаадай ашак бистиң карактарывысты дешкеш, салгылапты дижип ыглажып- сыктажып билдиргеннер.

-Кижиниң ийи кара кускуннарының карактарын дөжип турар кончуг хоранның кулугур боор ой! Бумбаадайның Эки - Боразын чип кааптыңар! - дээш, хаан ийи көк бөрүзүн бадырывыт - тыр эвеспе.

Күжүр Бумбаадай чүзү боор, ону билип кааш, Эки-Боразының орнунга Багай-Боразын баглааш, Эки-Боразын куу аът мына кылдыр хуулдургаш, так кылдыр чакырып кааш, удуп чыдып ап-тыр.

Хаанның айбычылары ийи көк бөрү чедип келгеш, ашактың Багай - Боразын чип кааннар.

Ашак эртен туруп кээрге, Бага-Боразын ийи бөрү чип алгаш, дезип бар чытканнар.

Күжүр ашак Эки-Боразын мунгаш, ийи көк бөрүнү Болчаглыг-Бора-Тейин үш долгандыр сывырып туруп, туткулап алгаш, хамык кезин бажынга дээр тулуптай сойгаш, салып чорудувут-тур.

Ийи көк бөрү ол -ла чоруткаш, хаанынга баргаш:

-Муң кара хойлуг Бумбаадай бистиң кештеривисти бажывыска чедир тулуптай сойгаш, салыпты! дишкен.

Хаан олура, улам хорадап:

-Чоп кончуг хоранның кулугур боор ой, кижиниң ийи көк бөрүзүнүң кештерин тулуптай союп турар! Бумбаадайның бодун барып өлүрүп кааптыңар! - дээш, ийи шивишкинин чорудупкан.

Күжүр Бумбаадай ону билип кааш, багай чадырын чаңгы-даа дыдык чок кылдыр дуглап алгаш, так кылдыр базыртынгаш, удуп чыдып ап-тыр.

Хаанның ийи шивишкини чедип келгеш, Бумбаадайның багай чадырын даңны атсы чүү-даа чок кылдыр үсперлеп, часпарлап тура хонганнар.

Бумбаадай дангаар эртен тура халааш, ийи шивишкинни Болчаглыг-Бора-Тейни долгандыр сывырып тургаш, туткулап алгаш, карактарын дешкеш, кырыларын сыккалааш салыпкан. Ийи шивишкин ол-ла чоруткаш, хаанынга чугаалааннар:

-Муң кара хойлуг Бумбаадай бистин карактарывысты дешкеш, кырыларывысты сыккаш, салгылапты!-деп ыглашкан кээп-тирлер.

Хаан ора :

-Кижинин шивишкиннеринин карактарын дежип, кырыларын сып турар кончуг хоранныг кулугур боор. Бумбаадайның бодун багай чадыры-биле катай чаңнык дүжүрүп кааптыңар ! ийи улу бадырыпкан.

Күжүр Бумбаадай ону билип кааш, багай чадырын болчаглыг бора тейнин бажынга барып хондургаш, аңаа турган даш оваазын чадырының орнунга эккеп тиккеш, оон иштинге даш көжээ олурткаш, багай чадырының ойбак черинден бакылап чыдарга, кезек кара булут халып, чаап келген соонда, чаңнык-даа чыжырткайны-ла берген. Даш оваазын чүү даа чок кылдыр чуура шаап каавыдып-тыр оо ! Бумбаадай ашак хорадавас боду хорадап, ажынмас боду ажынып келгеш, Эки-Боразын мунгаш, ийн улуну-даа сүрүп-ле каа -тыр эвесне.

Каптагайны хайылдыр , делегейин дескиндир сывырып тургаш туткулап алгаш, хамык кештерин тулуптай сойгаш, буттарының ээжээнге арттырып кааш, салыпкан .

Ийи улу ол-ла чоруткаш, хаанынга барып билдиртирге, хаан хорадавас боду хорадап, ажына боду ажынып келгеш, чоруп каап-тыр эвеспе.

Бумбаадайга чедип келгеш:

-Мээң ийи кара кускуннарым карактарын чүге дешкилеп кагдың ?

-Мээң муң кара хоюмнун иштинден ийи ак хураган төрүүрге, чүге оларның ийи карактарын деже соктаарыл ынчаш ?

-А мээң ийи көк бөрүмнүн хамык кештерин бажынга дээр чүге тулуптай сойдун ?

-Силер мээң Эки-Борамны чизин дээш ба дырыптарыңарга, Багай-Борамны чүге чигенил ынчаш ?

-А мээң ийи шивишкиннеримнин карактарын дешкеш, ийи кырыларын чүге сыккаш, чорудуптун ?

-Силер мени өлүрзүн дээш бадырыптарыңарга, мени өлүрбейн, харын мээң багай чадырымны чүге орбарлаарларыл ? -А мээң ийи улумнун хамык кештерин будунун ээжээнге дээр чүге тулуптай сойдун?

-Силер мээң багай чадырымны ыйбаландыр чаңнык дүжүрүп кааптыңар дээш бадырыптарыңарга, мээң чадырымга чаңнык дүжүрбейн, Болчаглыг-Бора-Тей бажында даш оваамга чүге чаңнык дүжүргенил ынчаш ?

-Хамык яла боттарында кулугурлар-дыр оң! дээш, хаан хамык чүвени көргөш, дүвү-далаш биле хап чана берип-тир оо ! (Матпаадыр 1990: 155-157)

Мянган хар хоньтой Бумбаадай

За хө, дээр цагт өглөөний эртэд урьдын урьдад бухын эвэр хугаран унаж хавтгай юмс салхинд хийсч бөөрөнхий юмс газраар өнхөрч байх цагт юм сан жээ.

Хавцал уруудсан Хар голын хөндийд нутагтай мянган хар хоньтой Эки - Бора, Багай - Бора хоёр морьтой Бумбаадай өвгөн амьдарч байжээ.

Бумбаадай өвгөн нэг өглөө хоньдынхоо бүрэн бүтнийг нь шалгатал нэг хонь

хоёр цагаан хурга төрүүлсэн байжээ. Өвгөн түүнд баярлаад, утаатай хар урцандаа алхаж ирээд хоёр уут оёж аваад гэдрэг алхаад очтол хоёр хар хурганы нүдийг нь хоёр хар хэрээ ухаад идсэн байж гэнэ. Өвгөн ч уурлаагүйгээрээ уурлаж, уцаарлаагүйгээрээ уцаарлаж Эки-Бора морио унаж хоёр хар хэрээг Болчаглыг-Бора толгойг гурав тойрон хөөж гүйцээд барьж аваад хэрээнүүдийн нүдийг ухаж тавиад явуулжээ.

Энэ одоо юу болов, гээд сайх хоёр хар хэрээ нисээд дээд оронд хурмастын хаанд хүрч очоод:

-Мянган хар хоньтой Бумбаадай өвгөн бидний нүдийг цоо хатгаад, тавьсан гэж уйлан унжин хэлжээ.

-Хүний хоёр хар хэрээний нүдийг цоо хатгадаг, яасан хорон муу хулгар вэ! Бумбаадайн Эки Бораг идээтэх! гэж... хоёр хөх чоноо илгээв гэнэ. Хөөрхий Бумбаадай тэгээд ч түүнийг мэдэж аваад Эки-Борагийн оронд Багай-Борагаа уяад Эки-Борагаа адууны шивх болгон хувиргаад чандлан нуугаад унтжээ.

Хаанын зараалчин хоёр хөх чоно хүрч ирээд өвгөний Багай-Бораг нь идчихжээ.

Өвгөн өглөө босоод ирэхэд Багай-Бораг нь хоёр чоно идээд зугтсан байжээ.

Хөөрхий өвгөн сайн бороо унаад хоёр хөх чоныг Болчаглыг-Бора толгойг гурав тойрч хөөгөөд барьж аван хамаг арьсыг нь толгойд нь хүртэл туламлан өвчөөд тавиад явуулжээ. Хоёр хөх чоно тийн яваад хаандаа очоод

-Мянган хар хоньтой Бумбаадай бидний арьсыг толгой хүртэл туламлан өвчөөд тавиад явууллаа гэжээ.

Хаан улам уурлан:

-Ямар муухай хорон хулгар вэ, хүний хоёр чонын арьсыг туламлан хуулдаг! Бумбаадайг өөрийг нь хөнөөгөөтөх! гэж хоёр шивэгчин явуулжээ.

Хөөрхий Бумбаадай түүнийг мэдчихээд муу урцаа ямар ч цоорхой нөхөөсгүй болтол нь битүүлээд, бөх гэгч нь хучаад унтаад өгчээ. Хааны хоёр шивэгчин хүрч ирээд Бумбаадайн муу урцыг үүр цайтал юу ч үгүй болтол эвдлэн хэмхчиж хоножээ. Бумбаадай үүрээр өглөө босод хоёр шивэгчиний болзоотын бор толгой тойрон элдэж барьж аван нүдийг нь сохолж царвууны ясыг нь хугачиж тавиад явуулжээ.

Хоёр шивэгчин тийн яваад хаандаа хэлжээ.

-Мянган хар хоньтой бумбаадай бидний нүдийг сохолж, царвууны ясыг хугачиж тавиад явууллаа гэж уйлалдан иржээ.

Хаан :

-Хүний шивэгчнүүдийн нүдийг нь сохолж царвууны ясыг нь хугалдаг ямар хорон хулгар вэ? Бумбаадай өөр дээр нь бас муу урцанд нь аянга буулгаад ир! гэж хоёр луу явуулжээ

Хөөрхий Бумбаадай түүнийг мэдээд муу урцаа Болчаглыг-Бора толгойн оройд аваачин бариад, тэндэхийн чулуун овооноос урцынхаа оронд авчирч овоолоод дотор нь чулуун хөшөө босгон муу урцныхаа ажигалаж байтал, хэсэг хар үүл гарч бороо орон аянга нүргэлжээ. Чулуун овоог юу ч үгүй болтол бут ниргэжээ. Бумбаадай өвгөн уурлаагүйгээрээ уурлан уцаарлаагүйгээрээ уцаарлан Эки-Борагаа унаад хоёр лууг ч хөөн нэхжээ. Хавтгайг хайлуулж дэлхийг эргүүлж хөөж элдээд барьж авч хамаг арьсыг нь тулалан өвчиж хөлний уланд нь үлдээгээд тавин явуулжээ.

Хоёр том луу тийн яваад хаандаа очиж хэлэхэд хаан хилэгнээгүйгээрээ хилэгнэж хордоогүйгээрээ хордож өөрөө өвгөн лүү явжээ.

Бумбаадайд хүрч очоод:

-Чи миний хар хэрээнүүдийн нүдийг яагаад сохолсон бэ? гэхэд

-Хоёр хар хэрээ чинь яах гэж миний мянган хар хонин дундаас хоёр цагаан хурга төрөхөд хоёр нүдийг нь сохолсон бэ? гэж өвгөн зөрүүлээд асуужээ

Хаан:

-Чи яах гэж миний хоёр хөх чонын хамаг арьсыг толгойд нь хүртэл туламлан өвчөө вэ? гэж асуухад

-Таныг миний Эки – Бора морийг идэг гэж явуулсан байтал тэд яагаад Багай – Бора морийг минь идэв? гэж зөрүүлэн асуужээ.

-Чи яах гэж миний хоёр шивэгчний нүдийг сохолж, хоёр царвууны ясыг нь хугалсан юм? гэхэд

-Та намайг хөнөөх гэж явуулсан байтал тэд яагаад намайг алалгүй муу урцыг минь эвдсэн юм гэж өвгөн зөрүүлэн асуув

-Чи яах гэж миний лууны хамаг арьсыг хөлийнх нь ул хүртэл туламлаж тавив? гэж асуухад

-Та миний муу урцыг ниргэж аянга буулга гэж явуулсан байтал тэд яах гэж миний урцад аянга буулгалгүй болзоотын бор толгойн ород байх овоонд минь аянгаар ниргэсэн юм? гэж зөрүүлэн асуужээ

-Таны хулгарууд өөрсдөө бүхэнд буруутай гэж өвгөн хэлмэгц хаан хаан бүхнийг хараад хамаг хурдаараа буцаад явчихжээ !

Бидний харьцуулан авч үзэж буй “Бэтгэлжин бор шувуу”, “Бэлтгэлжин бор шувуу” гэх монгол үлгэрүүд тува “Бора-Хөкпеш” (Богширго), “Шиигегей кушкаш” (Ногоолзой бялзуухай) гэх тува үлгэрүүд адил өгүүлэмжтэй бөөгнөл хувилбар үлгэрүүд болно.

Бэтгэлжин бор шувуу

Эрт урьд цагт нар сая мандаж, навч сая дэлгэрч, төр сая тогтож, түмэн сая хурж байхад Бэтгэлжин бор шувуу гэж байж гэнэ. Тэр шувуу өвлийн хүйтэнд өлсөнө гэж, хаврын хатууд харшина гэж хайртай бэтгэ гүеэндээ чимх будаа чихэж, атга будаа агуулсан юм байжээ.

Тэгээд нэг өдөр тэнгэрт нисэж ядраад харгана сондуул дээр суутал хайртай бэтгийг нь хагалчих гээд хатгаад байж гэнэ. Тэгэхлээр нь “Чамайг тэгвэл ямаагаар идүүлнэ дээ” гээд харганыг занаад Бэтгэлжин бор шувуу ямаанд очиж:

-Ямаа гуай, ямаа гуай! Харгана сондуул хайртай бэтгийг минь хагалчих гээд байна. Харганыг та идээд өгөөч! гэж гуйж гэнэ. Гэтэл ямаа:

-Чиний хатсан харганыг идэх байтугай, шимтэй ногоогоо идэж барахгүй яая гэж байна гээд тоосонгүй гэнэ. Тэгэхлээр нь Бэтгэлжин бор шувуу “Чамайг тэгвэл чоноор идүүлнэ дээ” гэж ямааг занаад чононд очиж:

-Чоно гуай, чоно гуай! Харгана сондуул хайртай бэтгийг минь хагалчих гээд байна. Харганыг хар ямаа идэж өгөхгүй байна. Хар ямааг та идээд өгөөч! гэж гуйжээ. Тэгтэл чоно:

-Чиний туранхай ямааг идэх нь байтугай, тураг гөрөөсөө яаж идэх билээ гэж явна гээд тоосонгүй гэнэ. Тэгэхлээр нь бэтгэлжин бор шувуу “Чамайг тэгвэл анчингаар алуулна даа” гэж чоныг занаад анчин хар хүнд очиж:

-Анчин гуай, анчин гуай! Харгана хайртай бэтгийг минь хагалчих гээд байна. Харганыг хар ямаа идэж өгөхгүй байна. Хар ямааг хөх чоно идэж өгөхгүй байна. Хөх чоныг та хөөгөөд намнаад өгөөч! гэж гуйжээ. Тэгтэл анчин:

-Гуриатсан чонотой хөөцөлдөх нь байтугай, гуу жалгын гөрөөсөө намнаж чадахгүй явна гээд бас тоосонгүй гэнэ. Тэгэхлээр нь Бэтгэлжин бор шувуу “Хулганаар чиний хувцсыг чинь уруулж хорлоно доо” гэж занаад хулганад очиж:

-Хулгана гуай, хулгана гуай! Харгана хайртай бэтгийг минь хагалчих гээд байна. Харганыг хар ямаа идэж өгөхгүй байна. Хар ямааг хөх чоно идэж өгөхгүй байна. Хөх чоныг анчин хөөж намнаж өгөхгүй байна. Анчин эрийн хувцсыг чи ураад ноохойлоод өгөөч! гэж гуйжээ. Тэгтэл хулгана:

-Гөрөөчний дээл ноохойлох нь байтугай, хөөгөө яаж хурааа гэж ядаж явна гээд тоосонгүй гэнэ. Тэгэхлээр нь Бэтгэлжин бор шувуу “Чамайг тэгвэл хургачин хүүгээр алуулна даа” гэж хулганыг занаад хургачин хүүд очиж:

-Хургачин хүү, хургачин хүү! Харгана сондуул хайртай бэтгийг минь хагалчих гээд байна. Харганыг хар ямаа идэж өгөхгүй байна. Хар ямааг хөх чоно идэж өгөхгүй байна. Хөх чоныг гөрөөчин хөөж намнаж өгөхгүй байна. Гөрөөчний дээлийг хулгана ноохойлж өгөхгүй байна. Хулганыг чи хувин ус цутгаад алаад өгөөч! гэж гуйжээ. Гэтэл хургачин хүү:

-Хулгана зурамтай хөөцөлдөх нь байтугай, хурга ишгээ хариулж гүйцэхгүй аая гэж явна гээд тоосонгүй гэнэ. Тэгэхлээр нь Бэтгэлжин бор шувуу “Чамайг тэгвэл аав ээжээр чинь зодуулна даа” гэж хургачин хүүг занаад аав ээжид нь очтол тэднийх эсгийгээ хийх гээд унгасаа савж байжээ. Бэтгэлжин бор шувуу аав ээжид нь очоод:

-Харгана сондуул хайртай бэтгийг минь хагалчих гээд байна. Харганыг хар ямаа идэж өгөхгүй байна. Хар ямааг хөх чоно идэж өгөхгүй байна. Хөх чоныг гөрөөчин эр алж өгөхгүй байна. Гөрөөчний хөдсөн дээлийг хулгана ноохойлж өгөхгүй байна. Хулганыг хургачин хүү чинь алж өгөхгүй байна. Хургачин хүүгээ нэг сайн зодоод өгөөч! гэж гуйжээ. Тэгтэл хүүгийн аав ээж хоёр нь:

-Тархигүй хүүхэдтэй хөөцөлдөх нь байтугай, тараасан унгасаа савж амжихгүй аая ийя гэж байна гээд тоосонгүй гэнэ. Тэгэхлээр нь Бэтгэлжин бор шувуу “Тэгвэл та нарын унгасыг чинь уул талаар нэг болгоно доо” гэж занаад салхи гаргахаар шийдэж, болзоотын бор толгой дээр гараад байдаг чадлаараа исгэрэн жиргэж гарчээ.

Тэгтэл салхи шуурга дэгдэж, савсан унгасыг хийсгэжээ. Ингээд хүүгийн аав ээж хоёр Бэтгэлжин бор шувуунд очиж “Салхи шуургаа намдааж өгөөч, бид хургачин хүүгээ зодоод өгье” гэж амлажээ. Хургачин хүүг хулгана алж өг гэж зодох болсонд, хургачин хүү “Хулганыг алаад өгье” гэж амлажээ. Хургачин хүү хулганыг алахаар очиход, хулгана “Гөрөөчний хөдсөн дээлийг ноохойлоод өгье” гэж амлажээ. Хулгана гөрөөчний дээлийг ноохойлох болоход, гөрөөчин эр “Хөх чоныг хөөж намнаж өгье” гэж амлажээ. Хөх чоныг гөрөөчин хөөж алах болоход чоно “Хар ямааг би хага татаад өгье” гэж амлажээ. Хар ямааг хага татахаар чоныг очиход, хар ямаа нь “Харгана сондуулыг идээд өгье” гэж амлажээ. Хар ямаа

харгана сондуулыг идэхээр очиход, харгана сондуул “Бэтгэлжин бор шувууны хайртай бэтгийг би хагалахаа байя” гэж ам тангараг өгчээ. Тэгээд Бэтгэлжин бор шувуу хайртай бэтгээ хамгаалан чадаад амар сайхандаа жаргав гэнэ.(Цэрэнсодном 1982:54-56)

Бэлтгэлжин бор шувуу

Бэлтгэлжин бор шувуу бөөн шарилжин дээр бууж очоод суужээ. Гэтэл бор шувууны гэдсийг хатгажээ. Тэхээр нь за чамайг ямаанд идүүлье гэж бор шувуу занаж хэлээд,

-Ямаа гуай, ямаа гуай идүүштэй шарилж энд нэг байна, идээд орхиоч гэжээ.

-Чиний шарилжийг идэх байтугай, ишгээ даахгүй явна гэж ямаа хэлээд цаашаа явахад,

-Чамайг сайн чадъя. Чононд очиж хэлье гээд бор шувуу явж боохолдойтой дайралдаад,

-Чоно гуай, чоно гуай энд идүүштэй ямаа нэг байн, идээд өгөөч гэсэнд,

-Чиний ямааг идэх байтугай өөрийнхөө бэлтрэгийг даахгүй байна гэж хэлээд чоно явжээ. Бор шувуу цаашаа явж хүнтэй дайралдаад,

-Хүн гуай, хүн гуай энд алууштай чоно нэг байна. Алаад өгөөч гэхэд, чиний чонийг алах нь байтугай өөрийгөө яая гэж явна гэсэнд, шувуу юу ч хэлсэнгүй шууд цаашаа явжээ.

Бор шувуу явсаар оготнотой дайралдаж,

-Оготно гуай, оготно гуай энд нэг хорлууштай хүн байна, хорлоод өгөөч гэсэнд, хүнийг хорлох нь байтугай хөрөнгөө бэлтгэж чадахгүй байна гэжээ. Бор шувуу, чамайг гэж занан зам дагаж явсаар хүүхэдтэй очиж уулзаад,

-Хүүхдээ, хүүхдээ энд алууштай оготно байна, алаад өгөөч гэсэнд,

-Чиний оготныг алах нь байтугай тугалаа нийлүүлчихээд тэвдэж явна гэхэд,

-Чамайг ээжид чинь хэлээд нэг сайн зодуулья гэж бор шувуу бодоод, эсгий хийж байгаа эмгэн чавганцынд очоод,

-Энд нэг зодууштай хүүхэд байна. Зодоод өгөөч гэсэнд,

-Чиний хүүхдийг зодох байтугай эсгий хийгээд завгүй байна гэжээ. Бэлтгэлжин бор шувуу нисээд, Болзоотын бор толгой дээр гарч, байдаг чадлаараа хашгирч орхисон чинь бараг тэнгэр газар нийлмээр хүчтэй салхи болжээ. Тэхэд нь эмгэн цочиж хүүхдийг барьж зодож, хүүхэд оготныг цохиж, оготно хүнийг хорлож, хүн чоныг зодож, чоно ямааг хазаж, ямаа шарилжийг идэж амар сайхан жаргажээ. (Дашдорж, Гүр-Рэнцэн 1958: 46)

Бора-Хөкпеш

Шаг шагның бажында эки оыт думчуундан үс ап, эки ыт думчуундан арага ап турар шагда кушкаш-кашкаш хола хараган бажынга олурбас, өшкү анай хола хараган бажы дайнавас шагда чүвең иргин.

Бора-хөкпеш бир-ле хараган бажынга хонупкаш бөскээнге тен кадап ап-тыр. Бора-Хөкпеш ийи анайлыг өшкүче келгеш: Мээң бөскээмде тени ап каавыдып көрем. Хола хараганның бажы үзе дайнап чивит –дээн .

-Сээң бөскээнде тени ап, хола хараганның бажын дайнаарындан ийи анайым өстүрүп чапап чор мен.

Ол-ла ушкаш, чеди бөрүгө кээп-тир.

-Мээң бөскээмде тени ап каавыдып көрүңер –деп- тир.

Чеди бөрү тургаш :

– Сээң бөскээнде тени алыр хамаан чок, Караты хаанның мал- маганы өлүп туруп берген оон эьдин чиир дээш чадап тур бис – дээн. Бора- Хөпеш ол-ла чоруткаш баг хап ойнаан оолдарга келгеш:

-Мээң бөскээмде тени ап каавыдып көрүңер –дээрге,

-Сээң бөскээнде тен алыр хамаан чок, баг хакчып чадап тур бис дээн. Бора- Хөкпеш чоруткаш эдек бышкан уругларга чеде берген.

–Уруглар уруглар Мээң бөскээмде тени ап каавыдып көрүңер-деп-тир.

-Сээң бөскээнде тен алыр хамаан чок эдээвис быжып чадап тур бис – дишкеннер

Бора Хөкпеш ол-ла чоруткаш дүк салган кадайларга келген:

-Мээң бөскээмде тени ап каавыдып көрүңер, угбарым. Бо эдек быжкан уругларның пөзүн үзе чаза соп кааптып көрүңер деп тир.

-Сээң бөскээнде тен алыр, уругларның пөзүн үзе чаза согар хамаан чок дүгүвүс салып чадап турар бис –дишкеннер. Бора Хөкпеш ол-ла чоруткаш дүк каккан ашактарга келгеш:

